



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Монгол Улсын Шадар сайдын төсвийн
2014 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/02/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

АГУУЛГА

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
Цахим хаяг:
tserendorjd@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

Аудитын тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн
горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр
дүн
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн
талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх
тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн
нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Менежментийн захидал

Аудитын гэрчилгээ

Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан
Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан
Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн
өөрчлөлтийн тайлан
Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-2015/02-СТА-ТЕЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 5-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Ахлах аудитор Д.Цэрэндорж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 8-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 16-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 4 дүгээр сарын 27-нд Монгол Улсын Шадар сайдад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад хамаарагдах газрууд нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын хүрээнд санхүүгийн үйл ажиллагааг явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

- Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үндсэн чиг үүрэг нь Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг болзошгүй байгалийн, хүний, техникийн болон технологийн аюул ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийн аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэх;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтыг төрийн бодлого, олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, чиглэлийн хяналт, шалгалтын боловсон хүчний мэргэжлийн чадавхийг бэхжүүлэх, мэргэжлийн хяналтын болон салбарын хууль, тогтоомж, үндэсний стандарт, дүрэм, журмыг боловсронгуй болгоход бүх талын дэмжлэг үзүүлэх ажлыг зохицуулах, хэрэгжүүлэх;
- Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, итгэмжлэл, баталгаажуулалт, сорьцын хяналтын бодлогоор дэмжих;
- Худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг ил тод, шударга болгох; гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байна” гэж заасны дагуу Монгол Улсын Шадар сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай болон холбогдох бусад хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 17-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, өмнөх аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын харьяа зарим байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль хяналтын байгууллагад шийдвэрлүүлэхээр өгсөн асуудлын шийдвэрлэлт удаашралтай байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилах зэргээр гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад 2014 онд улсын төсвөөс 107,599.9 сая, төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлогоос 4,810.6 сая, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх (1,114.6) сая, нийт 111,295.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнээс урсгал зардалд 82,623.1 сая төгрөг батлагдсанаас 81,395.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 1,227.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Нийт төсөвт зардлын 55.2 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, 19.1 хувийг хөрөнгө оруулалт, 25.7 хувийг бараа ажил үйлчилгээний зардал эзэлж байна.

Төв төрийн сангаас батлагдсан төсвийн хуваарьт сар бүрийн зарцуулалтын эрхийн баталгааг үндэслэн харилцах дансанд бодит гүйцэтгэлээр 86,316.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн нээж, Үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,771.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 39.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч үлдэгдэл 1,682.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн төлөвлөлтийн талаар: УИХ-аар Монгол Улсын Шадар сайдын төсвийн багц нь 2014 оны 5 дугаар сарын 23-ны тодотгосон төсвийг 120,118.9 сая төгрөгөөр батлагдсан ба 12 дугаар сарын 18-ны өдөр 114,561.7 сая төгрөгөөр батлагдсан.

Төсөвт зардлын талаар: 2014 оны төсөвт зардал 114,561.7 сая төгрөгөөр батлагдсанаас 111,383.2 сая төгрөг зарцуулж нийт батлагдсан төсвийн 97.2 хувийг санхүүжилтээр олгож, төсөвт зардал 3,178.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн үзүүлэлттэй байна.

Хөрөнгө оруулалтын талаар: 2014 онд хөрөнгө оруулалтын зардалд 23,044.6 сая төгрөг батлагдсанаас 21,283.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 1,761.2 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

2014 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаар 210,216.8 сая төгрөгийн нийт хөрөнгө илэрхийлэгдсэнээс 57.2 хувь буюу 120,292.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2.9 хувь буюу 6,095.5 сая төгрөгийн авлага болон урьдчилгаа, 39.8 хувь буюу 83,727.6 сая төгрөгийн бараа материал, 0.1 хувь буюу 101.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн 42.0 хувийг барилга байгууламж, 19.0 хувийг тээврийн хэрэгсэл, 17.0 хувийг машин тоног төхөөрөмж, 0.1 хувийг зам гүүр, 0.8 хувийг хамгаалалтын тоног төхөөрөмж, 1.5 хувийг бусад үндсэн хөрөнгө 16.8 хувийг дуусаагүй барилга байгууламж, 2.7 хувийг тавилга эд хогшил, 0.1 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн талаар: 2014 оны эхний үлдэгдэл 176,842.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, тайлант хугацаанд 13,615.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 3,530.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар хүлээн авсан, ТӨХ-ийн тогтоолоор балансаас балансад 5.746.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч нийт 25,155.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 1.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж, 1,173.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг актлан хасагдсан ба элэгдлийн зардал 76,879.1 сая төгрөг гарч, оны эцэст 120,292.1 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий хөрөнгөтэй байна.

Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан журам, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн “Шилэн дансны тухай хуулийн дагуу” багцын байгууллагууддаа өөрийн цахим хуудас болон Шилэн дансны цахим хуудсанд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг байршуулж байхыг албан бичгээр мэдэгдсэн.

Мөн байгууллага бүр шилэн дансанд байршуулсан төсвийн гүйцэтгэлийн мэдээллээ улирал тутам гаргаж дараа сарын 10-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлэхийг үүрэг болгон хяналт тавин ажиллаж байна. Багцын байгууллагуудын 2015 оны 1 дүгээр улирлын Шилэн дансны хэрэгжилтийн талаарх тайланг нэгтгэн Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газарт хүргүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад хамрагдах 5 төсвийн шууд захирагч, 3 төсвийн төвлөрүүлэн захирагч аудитад хамрагдахаас, төсөвт зардлын 99.6 хувийг Үндэсний аудитын газар санхүүгийн тайланд аудит хийж, 0.4 хувийг буюу Тяньжинь дэх Улаанбаатарын төлөөлөгчийн газар, УИХ-ын ордон төслийн нэгжид санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй байна

Аудитад хамрагдсан Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандартчилал, хэмжил зүйн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Худалдан авах ажиллагааны газар, Оюуны өмчийн газруудын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгөгдсөн байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандартчилал, хэмжил зүйн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Худалдан авах ажиллагааны газар, Оюуны өмчийн газруудын аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэл тайлан руу тулган баталгаажуулалт хийж шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Материаллаг байдлыг нийт орлогын 2 хувиар буюу 1,633.7 сая төгрөгөөр тооцсон.

2014 оны Төсвийн тухай хуулинд олон удаа өөрчлөлт хийгдсэнээс шалтгаалан Стандартчилал, хэмжил зүйн газар 602.0 сая төгрөг, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 53.3 сая төгрөг, Оюуны өмчийн газар 8.2 сая төгрөгийн зөрүүтэй батлагдсан төсвөөр төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргажээ.

Оюуны өмчийн газар 36.0 сая төгрөгөөр, Тяньжинь дэх Улаанбаатарын төлөөлөгчийн газар 6.0 сая төгрөгөөр батлагдсан төсвөө хэтрүүлэн зарцуулсан байна.

Салбар агентлагийн аудит хийгдсэн тайлангийн дүнг Шадар сайдын төсвийн багцын нэгтгэсэн тайлантай тулгалт хийж 2014 оны тайланд 351.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад залруулав.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 10,210.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 12.5 сая төгрөгийн 13 төлбөрийн акт, 34.0 сая төгрөгийн 16 албан шаардлага бичигдэж, 1,210.9 сая төгрөгийн 106 зөвлөмж өгч, 3,763.9 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн захирагчийн төсвийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Зөвлөмж

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар санхүүгийн тайлагналын талаар 1 зөвлөмж өглөө.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж. “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий Аудиторт санал болгож байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ШАДАР САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Асуудал 1

Санхүүгийн тайлагналын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Шадар сайдын төсвийн багцын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Шадар сайдын төсвийн багцын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Шадар сайдын төсвийн багцын ерөнхий нягтлан бодогч Ж.Бямбасүрэн, нэгтгэл хариуцсан нягтлан бодогч Э.Сарангуа болон салбарын санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1. Тайлагналын талаар

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн захирагчдын аудит хийгдсэн тайланг Шадар сайдын төсвийн багцын нэгтгэл тайлантай тулган баталгаажуулах явцад 351.1 сая төгрөгийн алдаа зөрчлүүд илэрлээ.

Санхүүгийн тайланг нэгтгүүлэхэд илэрсэн дээрх зөрчил нь УСНББОУС 1, 15 дугаар стандарттай, Батламж мэдэгдлийн “Иж бүрэн байх: бүртгэгдээгүй хөрөнгө, өр төлбөр, ажил гүйлгээ, үйл явдал буюу дэлгэж харуулаагүй зүйл үгүй байх” УСНББОУС 1, 12 стандарттай, Батламж мэдэгдлийн Толилуулга ба илчлэл: “аливаа зүйлийг холбогдох санхүүгийн тайлагналын баримтлалын дагуу дэлгэн харуулж, ангилж, тодорхойлсон байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаа хоцроож 2015 оны 4 дүгээр сарын 8-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Аудит хийгдсэн санхүүгийн тайланг Шадар сайдын төсвийн багцын нэгтгэл тайланд нэгтгэхдээ сайтар хянаж, зөв нэгтгэх, харьяа байгуулагуудын санхүүгийн ажилтнуудын чадавхижуулах, санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлж байх;

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэн байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

Г ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ, МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД У.ХҮРЭЛСҮХ
ТАНАА

2015.04.24 № 482
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,360,463,467.83	101,560,186.92
Кассанд байгаа бэлэн мөнгө	9,369,388.40	13,081,685.98
Төгрөг\ ЖМС	9,264,112.61	13,081,685.98
Гадаад валют	105,275.79	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,351,094,079.43	88,478,500.94
Төгрөг	1,351,094,079.43	88,478,500.94
Төсөвт байгууллагын харилцах	-	86,281,391.00
Тусгай зориулалтын сангийн харилцах	796,740,506.00	-
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	50,176,992.25	2,197,109.94
Нэмэлт санхүүжилтийн харилцах	504,176,581.18	-
АВЛАГА	4,547,339,139.41	5,010,209,693.15
Ажиллагчидтай холбогдсон авлага	8,738,508.25	13,052,840.22
Төлбөртэй үйлчилгээний авлага	26,819,359.00	56,578,352.00
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	155,861,392.41	117,351,861.85
Бусад авлага	4,355,919,879.75	4,823,226,639.08
Байгууллагаас авах авлага	4,200,478,935.87	4,621,524,260.78
Гэрэл цахилгааны авлага	1,300,200.00	-
Түлш халаалтын авлага	21,754.00	5,040,116.67
Дотоод албан томилолтын авлага	891,502.00	891,502.00
Эмийн авлага	2,522,920.00	-
Бусад зардлын тооцооны авлага	4,195,742,559.87	4,615,592,642.11
Хувь хүмүүсээс авах авлага	155,440,943.88	201,702,378.30
УРЬДЧИЛГАА	159,442,288.27	1,085,289,557.47
Бусад урьдчилгаа	159,442,288.27	1,085,289,557.47
Урьдчилгаа тооцоо	1,082,877.00	450,000.00
Цалингийн урьдчилгаа	1,082,877.00	450,000.00
Урьдчилж гарсан зардал	158,359,411.27	1,084,839,557.47
Урьдчилж төлсөн зардал	158,359,411.27	1,084,839,557.47
БАРАА МАТЕРИАЛ	24,493,803,217.16	25,774,458,314.68
Түүхий эд материал	8,774,059,895.43	10,010,852,700.67
Тусгай зориулалттай материал	8,056,647,011.56	9,135,952,998.73
Эм боох материал	296,443,419.23	425,567,612.36
Дуусаагүй үйлдвэрлэл	158,400,879.21	1,598,171.50
Бэлэн бүтээгдэхүүн	262,568,585.43	447,733,918.08
Хангамжийн материал	15,617,646,733.77	15,666,291,561.87
Бичиг хэргийн материал	209,410,141.45	231,127,963.42
Аж ахуйн материал	2,454,425,277.54	2,862,303,790.23
Сэлбэг хэрэгсэл	573,260,935.38	650,587,587.71
Түлш, шатах тослох материал	150,659,780.47	121,664,717.38
Барилгын засварын материал	20,187,698.76	16,841,897.95
Хүнсний материал	23,203,469.00	40,495,055.00
Баглаа боодол	10,308,700.62	85,777,128.41
Бусад бараа материал	12,176,190,730.55	11,657,493,421.77
Мал амьтад	61,850,549.85	58,589,299.85
Бусад	40,246,038.11	38,724,752.29
НӨӨЦ	53,247,144,204.79	57,953,224,281.34
Барааны нөөц	24,063,957,135.00	26,118,981,582.50
Үрийн нөөц	6,017,475,329.80	6,650,512,347.05
Шатахууны нөөц	18,866,300,422.05	21,770,380,369.92
Бусад нөөц	4,299,411,317.94	3,413,349,981.87

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,808,192,317.46	89,924,742,033.56
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	110,458,591,483.57	120,292,089,457.68
Биет хөрөнгө	110,194,860,829.32	120,102,910,925.34
Барилга, байгууламж, орон сууц	51,547,098,497.01	50,204,534,213.37
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	84,331,174,151.44	84,033,518,141.44
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(32,784,075,654.43)	(33,828,983,928.07)
Авто-тээврийн хэрэгсэл	21,531,823,991.30	22,570,163,742.06
Авто-тээврийн хэрэгсэл - Анхны өртөг	31,413,754,824.24	36,463,872,320.99
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(9,881,930,832.94)	(13,893,708,578.93)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	20,084,018,055.94	20,695,651,619.75
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	36,534,530,628.77	41,739,970,360.80
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(16,450,512,572.83)	(21,044,318,741.05)
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,575,465,534.57	3,255,062,777.29
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	6,438,564,170.19	6,592,382,439.49
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(2,863,098,635.62)	(3,337,319,662.20)
Зам, гүүрийн байгууламж	167,632,397.73	147,339,006.85
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	200,103,669.00	200,103,669.00
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(32,471,271.27)	(52,764,662.15)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1,452,700,208.75	1,083,929,220.68
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж - Анхны өртөг	3,447,198,485.44	2,945,680,851.15
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж - Хуримтлагдсан элэгдэл	(1,994,498,276.69)	(1,861,751,630.47)
Бусад үндсэн хөрөнгө	3,073,630,593.87	1,897,735,193.19
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	4,981,721,248.60	4,210,324,049.25
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(1,941,960,937.73)	(2,346,489,957.06)
Номын фонд	33,870,283.00	33,901,101.00
Дуусаагүй барилга, байгууламж	8,762,491,550.15	20,248,495,152.15
Биет бус хөрөнгө	263,730,654.25	189,178,532.34
Програм хангамж	234,657,106.98	166,365,659.30
Програм хангамж - Анхны өртөг	639,836,829.21	643,853,579.21
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(405,179,722.23)	(477,487,919.91)
Бусад биет бус хөрөнгө	29,073,547.27	22,812,873.04
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	59,040,650.00	59,106,650.00
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(29,967,102.73)	(36,293,776.96)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	194,266,783,801.03	210,216,831,491.24
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,531,120,498.88	875,969,071.88
Өглөг	1,531,120,498.88	875,969,071.88
Ажилчидтай холбогдсон тооцоо	16,901,968.81	37,625,766.58
Цалингийн өглөг	5,264,227.01	10,218,777.00
НДШ-ийн өглөг	3,113,139.29	21,400,801.99
ХАОАТ-ын өглөг	8,524,602.51	5,829,492.59
ҮЭ-ийн өглөг	-	176,695.00
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	58,252,763.07	270,742,365.44
Гэрэл цахилгааны тооцоо	25,000.00	95,864.00
Түлш халаалтын тооцоо	10,361,845.00	14,825,746.00
Шуудан холбооны тооцоо	554,276.20	652,683.00
Цэвэр, бохир усны тооцоо	-	678,590.00
Тээвэр шатахууны тооцоо	12,681,640.00	23,564,886.00
Эмийн тооцоо	16,340,442.47	1,688,065.00
Бусад зардлын тооцоо	18,289,559.40	229,236,531.44

Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо	736,634,570.00	387,587.00
Бусад өглөг	719,331,197.00	567,213,352.86
Байгууллагад төлөх өглөг	707,978,835.77	548,589,768.93
Хувь хүмүүст төлөх өглөг	11,352,361.23	18,623,583.93
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,531,120,498.88	875,969,071.88
Засгийн газрын хувь оролцоо	192,735,663,302.15	209,340,862,419.36
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	96,753,992,726.30	96,536,999,512.27
Хуримтлагдсан үр дүн	76,890,035,377.84	93,740,740,655.30
Өмнөх үеийн үр дүн	76,890,035,377.84	76,958,515,410.75
Тайлант үеийн үр дүн	-	16,782,225,244.55
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,091,635,198.01	19,063,122,251.79
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	192,735,663,302.15	209,340,862,419.36
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	194,266,783,801.03	210,216,831,491.24

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	127,770,261,198.74	115,796,221,959.46
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	127,770,261,198.74	115,796,221,959.46
Улсын төвлөрсөн төсвөөс	127,631,953,538.14	114,075,630,986.45
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	81,336,959,904.01	87,151,090,820.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	469,785,468.00	-
Засгийн газрын нөөц хөрөнгө	6,055,425,419.63	-
Хөрөнгийн	32,164,911,271.80	21,283,414,088.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	7,604,871,474.70	5,641,126,078.45
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	34,883,497.00	52,623,815.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	1,179,349,461.66	4,624,028,079.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	5,142,119,595.98	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	477,479,583.85	355,561,780.04
Төсвийн урамшуулал	771,039,336.21	608,912,404.41
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	55,527,102.60	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,500,000.00	-
Хөрөнгийн	30,027,102.60	-
Төсөвт байгууллагаас	4,260,000.00	1,610,062,718.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,260,000.00	616,917.00
Хөрөнгийн	-	1,609,445,801.00
Нийгмийн даатгалын сангаас	78,520,558.00	110,528,255.01
НДС-ийн шилжүүлэг	78,520,558.00	110,528,255.01
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,478,117,079.48	20,639,757,390.20
Бараа, үйлчилгээний борлуулалт	27,331,904,241.52	17,270,575,880.60
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	27,329,582,367.34	17,269,067,059.79
Үндсэн үйл ажиллагааны орлого	15,896,596,556.12	14,349,476,010.35
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	8,473,064,891.58	1,442,294,423.43
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,959,920,919.64	1,477,296,626.01
Захиргааны хураамж	2,321,874.18	1,508,820.81
Бусад захиргааны хураамж	2,321,874.18	1,508,820.81
Торгууль, шимтгэл	-	32,103,526.00
Тусламжаас бусад шилжүүлэг	25,826,246,330.26	-
Зээлийн орлого	25,826,246,330.26	-
Шинээр олголт	25,826,246,330.26	-
Татварын бус бусад орлого	47,319,966,507.70	3,337,077,983.60
Хөрөнгийн орлого	39,863,882,116.91	3,337,077,983.60
Ангилагдаагүй орлого	7,456,084,390.79	-
Ангилагдаагүй бусад орлого	7,456,084,390.79	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	228,248,378,278.22	136,435,979,349.66
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	57,179,085,954.81	61,465,217,848.57
Үндсэн болон нэмэгдэл цалин	53,879,004,759.78	57,878,281,234.16
Үндсэн цалин	50,106,854,103.89	53,912,623,513.64
Гэрээт ажилчдын цалин	2,095,278,755.89	2,292,769,473.71
Унаа хоолны хөнгөлөлт	1,082,896,849.00	1,206,766,893.00
Бусад нэмэгдлүүд	593,975,051.00	466,121,353.81
Үр дүнгийн урамшуулал	6,389,955.00	496,806.00

Унаа, болон бусад нөхөн олговор	471,585,276.00	465,624,547.81
Бусад нэмэгдэл	115,999,820.00	-
Нийгмийн хамгааллын шимтгэл	3,300,081,195.03	3,586,936,614.41
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	2,256,381,777.94	2,521,190,675.58
Тэтгэврийн даатгалын шимтгэл	1,782,600,006.10	2,062,948,222.17
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	178,741,096.52	175,485,231.61
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	224,981,923.77	222,115,851.75
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	70,058,751.55	60,641,370.05
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,043,699,417.09	1,065,745,938.83
УРСГАЛ ЗАРДАЛ	71,844,088,103.03	40,799,221,291.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	41,675,910,739.91	28,696,749,608.05
Тогтмол зардал	2,649,685,078.49	2,811,381,418.93
Гэрэл цахилгаан	530,318,185.10	590,384,875.87
Түлш, халаалт	1,911,828,019.73	1,999,417,900.03
Цэвэр, бохир ус	207,538,873.66	221,578,643.03
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	1,166,311,949.91	1,119,090,927.88
Хоол	682,859,410.49	710,595,875.94
Эм, вакцин	483,452,539.42	408,495,051.94
Бусад бараа үйлчилгээний зардал	37,859,913,711.51	24,766,277,261.24
Бичиг хэргийн зардал	440,738,540.36	491,146,328.81
Тээвэр, шатахуун	2,918,900,763.50	2,572,980,790.96
Шуудан, харилцаа холбоо	347,582,999.33	557,273,697.78
Дотоод албан томилолт	1,155,310,539.73	703,600,194.71
Гадаад албан томилолт	203,700,596.00	120,818,511.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	18,748,940.82	22,914,846.30
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	311,690,329.56	489,029,895.60
Сургалт семинарын зардал	186,295,925.90	12,746,392.00
Эрдэм шинжилгээний ажил хийх	138,403,214.56	97,096,369.11
Жижиг эд хогшил худалдан авах	117,537,255.61	613,850,461.69
Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\	55,534,908.71	551,750,656.55
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	-	2,029,904.00
Жижиг эд хогшил худалдан авах \Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл\	12,895,592.00	25,926,048.17
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\	48,811,754.90	34,143,852.97
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	295,000.00	-
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	4,248,633,501.43	3,331,900,987.43
Төлбөр хураамж, жижиг татварууд	1,606,881,643.42	1,074,592,423.56
Харуул, хамгаалалтын зардал	24,570,000.00	37,382,400.00
Банкны үйлчилгээний хураамж	7,600,860.00	42,507.88
